



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/126

Номгон

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 3” дэд хөтөлбөрийн төлөвлөгөө батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а, д” дэх заалт, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дах заалт, аймгийн ИТХТ-ийн 2020 оны 90 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 3” дэд хөтөлбөрийн 2021-2023 он хүртэл хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Арга хэмжээний төлөвлөгөөг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, арга зүйгээр ханган, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Баттөр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр Хүнс, хөдөө аж ахуйн газарт тайлагнахыг сумдын Засаг даргын Тамгын газарт, жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор төлөвлөгөөний үр дүнг тооцож Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Баттөр/-т тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210319

Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын
18-ны өдрийн А/126 дугаар захирамжийн хавсралт



**“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР-III”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилго		Аймаг, сумын ИТХурал, Засаг даргын тамгын газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршооны хөгжлийн эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, ажлын байрыг бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.				
Үр нөлөө (Үр нөлөөний шалгуур үзүүлэлт)		1. Төрийн байгууллага, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч бусад байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. 2. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлснээр хоршоод тогтвортой хөгжинө 3. Хоршооны бүтцэд тулгуурласан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоо бий болно. 4. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлснээр гишүүдийн итгэл нэмэгдэж хоршоод хөгжлийн шинэ шатанд хүрнэ.				
№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжил тийг хариуцах байгуул лага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж үр дүнг нэмэгдүүлэх						
1.1	Төрийн байгууллага, хоршооллын төлөөллийн байгууллагатай энэхүү хөтөлбөр хэрэгжих хугацаагаар хамтран ажиллах	Гэрээ байгуулах	Байгуулсан гэрээний тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын	2021-2023

1	2	3	4	5	6	7
	гэрээ, санамж бичиг байгуулан харилцан үүрэг хүлээж ажиллах				тамгын газар	
1.2	Тогтвортой хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хоршооны салбарын бодлоготой уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг хангах, үр дүнг тооцох	Уялдаа холбоог сайжруулах	Хамтын ажиллагааны үр дүн	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
1.3	Хоршооны хөгжилд бодитой үр дүн үзүүлсэн төслүүдийн "Сайн" туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, суралцах	Сайн туршлагыг дэлгэрүүлэх	Сурталчилсан үйл ажиллагааны тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
1.4	"Нэг сум-Нэг загвар хоршоо" тогтвортой хөгжлийн бодлогыг үйлдвэрлэл, борлуулалтын чиглэлээр орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	"Нэг сум-Нэг загвар хоршоо" хэрэгжүүлэх	Бий болсон загвар хоршоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
1.5	Салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ үүсгэх, мэдээлэл хүлээн авах, боловсруулах	Сангийн бүрдэл	Үнэн зөв илгээсэн мэдээлэл	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
1.6	Орон нутгийн хоршооны асуудал хариуцсан төрийн албан хаагчид (улсын бүртгэгч, татварын байцаагч, аймаг сумын хоршоо хариуцсан мэргэжилтэн, нийгмийн ажилтан гэх мэт.)- д хоршооны онцлогийг таниулсан сургалт зөвлөгөөнд хамруулах	Сургалтад хамрагдах	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан хүний тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
Үйл ажиллагааны чиглэл		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
Зорилт 2. Хоршоодыг хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх						
2.1	Жил бүрийн орон нутгийн төсөвт хоршооны хөгжлийг дэмжсэн асуудалд хөрөнгө шийдвэрлэх	Мөнгөн дүн	Төсөвт тусгасан мөнгө дүн	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023

1	2	3	4	5	6	7
2.2	Хөдөө аж ахуйн болон жижиг үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг захиалгаар нийлүүлэх, лизингээр олгох боломжийг бүрдүүлэх	Зуучилсан байх.	Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, мөнгөн дүн	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
2.3	Загвар хоршоодыг хөрөнгө, санхүүгээр дэмжих, тогтвортой ажиллуулах	Загвар хоршоодыг дэмжсэн байна	Дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
2.4	Хоршоодын хэрэгцээ, орон нутаг дахь барилга байгууламжийн ашиглалтын байдалд судалгаа хийж, зохицуулах	Барилга байгууламжийг хоршоодод эзэмшүүлэх	Хоршоодод эзэмшүүлсэн барилга байгууламжийн тоо, эзэмшүүлсэн хэлбэр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
Үйл ажиллагааны чиглэл		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
Зорилт 3. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих						
3.1	Сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих	Зээл тусламжид хамруулах	Зээл тусламжид хамрагдсан хоршооны тоо, мөнгөн дүн, эх үүсвэр	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
3.2	Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах	Сумдад тордолтын төвийг байгуулах	Тордолтын төвийн тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023

1	2	3	4	5	6	7
3.3	Хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх.	Түүхий эдийг биржээр арилжих	Арилжааны тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
3.4	Үндэсний үйлдвэрт, хоршоод бүтээгдэхүүнээ нийлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх.	Тогтолцоог бий болгох	Бүтээгдэхүүн нийлүүлсэн хоршооны нэр, бүтээгдэхүүний төрөл хэмжээ, мөнгөн дүн	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
Үйл ажиллагааны чиглэл		Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан болон шинэ үйл ажиллагааны чиглэл				
Зорилт 4. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх						
4.1	Хоршоодын үйл ажиллагааны цар хүрээ, ажлын үр дүн, нийгэмд эзлэх байр суурийн өсөлт зэргийг үндэслэн сумын шилдэг хоршоог жил бүр шалгаруулан урамшуулах, алдаршуулах	Шилдэг хоршоог шалгаруулж хэвших	Шалгаруулсан хоршооны нэр, үйл ажиллагааны чиглэл, давуу тал	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
4.2	Шилдэг хоршоодын ажлын туршлага, амжилтын жишээг хэвлэл, мэдээллээр сурталчлан нийтийн хүртээл болгох, жил бүр тусгай эмхтгэл болгон хэвлэж гаргах	Туршлагыг нийтэд дэлгэрүүлэх	Сурталчилсан мэдээллийн тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
4.3	Хоршооны бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах, нэр төрийн батламж олгох	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ, шалгаруулсан бүтээгдэхүүний чанар	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
4.4	Төрийн худалдан авалтад хоршооноос нийлүүлэх боломжтой бүтээгдэхүүний судалгаа явуулах, оролцоог хангах	Худалдан авалтад оролцох	Бүтээгдэхүүний нэр төрөл, мөнгөн дүн	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023

1	2	3	4	5	6	7
4.5	Хоршооны удирдлага, дотоод хяналтын бүтэц, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хариуцлагатай болгох	Хоршоодын удирдлагыг чадвартай болгох	Зохион байгуулсан сургалтын тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023
4.6	Залуу хоршоологч хөдөлгөөн өрнүүлэх, өсвөр үеийнхэнд хоршооны ач холбогдлыг ойлгуулан сурталчлах зэргээр хоршооллын хөдөлгөөний залгамж үеийг төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх	Залуу хоршоологчдыг бэлтгэх	Зохион байгуулсан сургалт, хамрагдсан иргэдийн тоо	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Сумдын Засаг даргын тамгын газар	2021-2023